



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/6259

Мандалговь

Г Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай
зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 16 дугаар зүйлийн 16.2.2 дахь заалт, эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудын тусгай зөвшөөрлийн хугацааг хавсралтад зааснаар сунгасугай.

Хоёр. Эрүүл мэндийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц үйл, үйл ажиллагаа MNS5081:2013, өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эмнэлэг, эмийн сангийн дарга нарт тус тус үүрэг болгосугай

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг тусгай зөвшөөрөл олгох комисс (А.Нарантуяа)-д, Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ ЭРДЭНЭ

020076*

Аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 12-ны
өдрийн 4212 тоот захирамжийн хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН
НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Үүсгэн байгуулагчийн нэр	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Хугацаа
1	Цагаандэлгэр сумын хүн эмнэлэг	Цагаандэлгэр ЭМТөв	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	ЭУ-15/10/997	3 жил	2018-01-29 2021-01-29
2	Луус сумын хүн эмнэлэг	Луус ЭМТөв	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	ЭУ-15/10/994	3 жил	2018-01-29 2021-01-29